



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭ**

2024

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

02-P CAP

Улаанбаатар хот

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааны багийн гишүүд:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)

Р.Хатансайхан

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
(LL.M)

Б.Ариунжаргал

Эрдэм шинжилгээний ажилтан

Х.Санчир

Эрдэм шинжилгээний ажилтан

**ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

АГУУЛГА

УДИРТГАЛ	5
НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	6
ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ	7
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	7
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	7
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	8
2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	8
ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	8
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	10
3.1.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлд заасан үзэл баримтлалтай Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн зорилт нийцсэн эсэх /Хуулийн төслийн 1 дүгээр зүйл/	10
3.1.2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын зарчмын тухайд /хуулийн төслийн 5 дугаар зүйл/	13
3.1.3. Үндэсний зөвлөлийн тухайд //хуулийн төслийн 14 дүгээр зүйл	17
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	22
3.2.1. Үндэсний зөвлөлийн чиг үүргийн тухайд /хуулийн төслийн 14 дүгээр зүйл 14.1/	22
3.2.2. Иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлын тайлангийн тухайд /хуулийн төслийн 19 дүгээр зүйл 14.1/	25
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	27
ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ	37
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	42

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АМтХ	Ашигт малтмалын тухай хууль
НМИТБтХ НҮБ	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдал

Хүснэгт 2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдал

Хүснэгт 3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдал

Хүснэгт 4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдал

Хүснэгт 5. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгсэл

Хүснэгт 6. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгсэл

Хүснэгт 7. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн зорилго

Хүснэгт 8. Монгол Улсын Үндсэн хууль болон олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн зүйл заалтын харилцан хамаарал

Хүснэгт 9. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд заасан зарчмууд.

Хүснэгт 10. ОУИТБС-ын зарчмууд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуульд тусгасан байдал.

Хүснэгт 11. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд заасан Үндэсний зөвлөлд хамаарах хэм хэмжээ

Хүснэгт 12. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд заасан Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд орох төрийн захиргааны төв байгууллага ба Монгол Улсын засгийн газрын тухай хуульд заасан төрийн захиргааны төв байгууллага, түүний эрхлэх асуудлын харьцуулалт

Хүснэгт 13. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

Хүснэгт 14. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлт болон Үндэсний зөвлөлийн эрх зүйн хэм хэмжээ 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт

Хүснэгт 15. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлт болон Иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлын тайлангийн талаарх эрх зүйн хэм хэмжээ

Хүснэгт 16 . Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хүснэгт 17. Эрдэс баялаг олборлох үйлдвэрлэл, эрдэс баялгийг олборлох үйлдвэрлэл гэж хоёр өөр байдлаар бичигдсэн төслийн зүйл заалт

Хүснэгт 18. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал

График 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслөөр ил тод, нээлттэй болгох мэдээллийн тоо

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж, тус зүйлийн 2 дахь хэсэгт “*Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ*” гэж, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт *Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг баталгаатай эдэлнэ* гэж, мөн тус зүйлийн 17-д “*төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй*” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.6 дахь заалтын 1-д “*Газар, түүний нөөцийг зохистой, үр дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдсэн байна.*” гэж, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.6 дахь заалтын 5-д “*олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах*” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 130 дугаар хэсэгт “*Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах*” гэж тус тус заасан.

Өөрөөр хэлбэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулан батлуулснаар Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйл, “Алсын хараа-2050” буюу Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.6 дугаар дахь заалтын 1 дэх, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.6 дугаар заалтын 5, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 130 дахь заалтыг хэрэгжих боломжтой бүрдэх юм .

Иймд уг судалгааны зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал /цаашид “Аргачлал” гэх/”-ийн дагуу “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд оршино.

“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар үнэллээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Журмын төслөөс үр нөлөө тооцох хэсгээ сонгох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Тухайлбал,

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн зорилт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын зарчим, Үндэсний зөвлөлийн эрх зүйн зохицуулалтыг сонгон авч зорилгод нийцсэн шалгуур үзүүлэлтийн дагуу; /Хуулийн төслийн 1 дүгээр зүйл, Хуулийн төслийн 5 дугаар зүйл, Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3/
2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн Үндэсний зөвлөл, иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлын тайлангийн эрх зүйн зохицуулалтыг практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн дагуу; /хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1/
3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх ойлгомжтой эсэхийг ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн дагуу;
4. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцсэн байдал, харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн дагуу тус тус үнэлэх болно.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авлаа. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож үр нөлөөг үнэлнэ.

Түүнчлэн, хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөө тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт бүрээр тус бүрд нь авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

Иймд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслөөс дээрх асуудлын дагуу зорилгодоо хүрсэн эсэхийг “зорилгод хүрэх байдал”-ийн үр нөлөөг тооцно. Үүнд:

Хүснэгт 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдал

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл заалт
1.	Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь заалтын үзэл баримтлал, зорилгод нийцсэн эсэх	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл, Хуулийн төслийн 5 дугаар зүйл, Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг..

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах агуулгын хүрээнд зохицуулалтуудыг сонгон “Практикт хэрэгжих боломж” гэх шалгуурын үр нөлөөг тооцсон болно.

Хүснэгт 2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдал

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
----------	---------------------------------	----------------------------

1.	Шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг	Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
----	--	--

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс нэр томъёоны тодорхойлолттой холбоотой хэсгийг сонгон авч үнэллээ.

Хүснэгт 3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдал

№	Ойлгомжтой байдал	Сонгосон зүйл заалт
1.	Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх	Хуулийн төсөл бүхэлдээ

2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг.

Хүснэгт 4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдал

№	Харилцан уялдаа	Сонгосон зүйл заалт
1.	Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалтыг шалгах	Хуулийн төсөл бүхэлдээ

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрд нийцсэн дараах шалгах хэрэгслийн дагуу үнэлгээ өгөхөөр тогтлоо.

Хүснэгт 5. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгсэл

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
Практикт хэрэгжих боломж	Практикт турших

Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Өмнөх үе шатуудад журмын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтсон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 6. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгсэл

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл, Хуулийн төслийн 5 дугаар зүйл, Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг.	Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлал болон тус хуулийн төслийн холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.	Практикт хэрэгжих байдлыг баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар хэрэгжих эсэхийг судлах
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Тодорхойлоогүй нэр томъёонуудыг тайлбарлах байдлаар санал болгох, хуулийн төсөл боловсруулах нийтлэг шаардлагад нийцүүлэх саналыг гаргах
4.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Харилцан уялдааг судлах, ингэхдээ сантай холбоотой төрийн байгууллагын байгууллагын бүрэн эрхэд дүн шинжилгээ хийх

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал”-ийг үнэлэхдээ хуулийн төсөл нь хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрэх үр дүн тодорхой байдлаар томъёологдож чадсан эсэхийг тухайн хуулийн төсөл, дээд эрэмбийн хуулийн үзэл баримтлал, түүний агуулгыг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж буй зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийдэг. Энэ хүрээнд хуулийн төслийн зорилго буюу 1.1 дэх хэсэг болон хуулийн төслийн бусад хэм хэмжээг бүхэлд нь хамруулан дүн шинжилгээ хийлээ.

Хүснэгт 7. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн зорилго

Хуулийн төслийн зорилго нь “байгалийн баялаг ашиглалтыг үндэсний ашиг сонирхолд нийцүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг дэмжих, байгалийн баялгийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх, олборлох үйлдвэрлэлийг байгальд сөрөг нөлөө багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлэх, байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанд олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлж, иргэний мэдэх эрхийг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зорилгоор олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Уг зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, зорилгод нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийсэн.

3.1.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлд заасан үзэл баримтлалтай Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн зорилт нийцсэн эсэх /Хуулийн төслийн 1 дүгээр зүйл/

Хүснэгт 8. Монгол Улсын Үндсэн хууль болон олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн зүйл заалтын харилцан хамаарал

<p>Монгол Улсын Үндсэн хуулийн зүйл, заалт</p>	<p>6.2.“Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.”</p> <p>16.2.“Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг баталгаатай эдэлнэ.”</p> <p>16.17. “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.”</p>
<p>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 1.1.</p>	<p>1.Байгалийн баялаг ашиглалтыг үндэсний ашиг сонирхолд нийцүүлэх;</p> <p>2.Эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг дэмжих;</p> <p>3.Байгалийн баялгийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх;</p> <p>4.Олборлох үйлдвэрлэлийг байгальд сөрөг нөлөө багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлэх;</p> <p>5.Байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанд олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлж, иргэний мэдэх эрхийг хангах;</p> <p>6.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зэрэг.</p>

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйл болон Арван зургадугаар зүйлтэй уялдаа холбоотой. Тодруулбал 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 1992 оны Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт гурван агуулга бүхий өөрчлөлт орсон. Үүний нэг нь *“Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрх”* юм. Уг заалтын үзэл баримтлал нь төр холбогдох мэдээллийг ил тод болгох, иргэд ямар нэг саадгүйгээр мэдэх бололцоог бүрдүүлэх, улмаар газрын хэвлийн баялгийг зохистой ашиглах, түүний байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлж байгаад иргэний хяналт тогтоох гэсэн утгатай.¹

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйл 2 дахь хэсэгт заасан *“Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрх”*-тэй холбоотой хэм хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2020 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас *“Монгол Улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай”* 02 дугаар тогтоолыг баталжээ.² Уг тогтоолын хавсралтаар *“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”*-ыг тогтоосон. Тус тогтоолын 1.1.4-д газрын хэвлийн баялаг ашигласны улмаас хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг хангах, байгалийн тэнцлийг хангах хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг баталгаажуулах, Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн эрхийг зөрчиж байгаа эсэхэд иргэд хөндлөнгийн хяналт тавих эрх зүйн үндсийг тогтоох³ арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн Газарт даалгасан.⁴ Гэвч Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйл 2 дахь хэсэгт заасан *“Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрх”*-ийг бодитоор хэрэгжүүлэх нь тулгамдаж буй асуудал болоод байна.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-д *“...эрүүл эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй...”* гэж заасан. Уг эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр тодорхой хууль тогтоомжийг батлаад байна. Гэвч ч гол асуудал нь эрх зүйн орчин бус, практикт уг эрх зүйн хэм хэмжээг дагаж, мөрдөх, хэрэгжүүлэх явдал болохыг НҮБ-ийн Хүний эрх ба Хүрээлэн бус орчны асуудал хариуцсан Тусгай илтгэгч Жон Нокс тайландаа дурджээ.⁵ Тэрээр хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол,

¹Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар*, УБ, Адмон, 2023, 84 дэх тал

²Монгол Улсын Их Хурлын тогтоол, 2020, Дугаар 02, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14950>.

³Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=210458&showType=1>.

⁴Монгол Улсын Их Хурлын тогтоол, 2020, Дугаар 02, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14950>.

⁵ НҮБ-ийн Хүний эрх ба Хүрээлэн буй орчны асуудал хариуцсан Тусгай илтгэгч Жон Ноксийн тайлан, 2017, 18-21 дэх тал.

байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хэрэгжүүлэх тулд хэд хэдэн чиглэлд анхаарахыг онцолсон. Үүний нэг нь шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн бодитой оролцоог хангах, мэдээлэл хайх, олж авах эрхийг хэрэгжүүлэх юм.⁶

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д заасан “...мэдээлэл хайх, хүлээн авах эрх...” нь Монгол Улсын олон улсын гэрээ-”Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 19 дүгээр зүйлд заасан “хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах...”, “санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх...” эрх, түүнийг зарим талаар хязгаарлах нөхцөл болзлыг тодорхойлсон.⁷ Тодруулбал Монгол Улсын олон улсын гэрээ-”Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу оролцогч улсууд нь бүх төрлийн мэдээлэл, үзэл бодлыг хил хязгаар харгалзахгүйгээр хайх, хүлээн авах, түгээхийг оролцуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулна. Энэ эрхэд 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 20 дугаар зүйлд нийцсэн, бусдад түгээх боломжтой бүх төрлийн үзэл бодол, илтгэл үнэмшлийг агуулсан мэдээллийг хүлээн авах, илэрхийлэх, үйлдлийг багтаана. Үүнд улс төрийн яриа хэлэлцүүлэг хийх, өөрийн болон нийтийн үйл хэргийн талаар тайлбар хийх, үзэл бодлыг биечлэн уулзаж тандах, хүний эрхийн асуудлаар яриа хэлэлцүүлэг хийх, сэтгүүл зүй, соёл урлагийн бүтээл туурвих, сурган хүмүүжүүлэх, шашны үйл ажиллагаа багтана.⁸

Түүнчлэн, 19 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийн хүрээнд төрийн байгууллагад байгаа мэдээллийг олж авах эрхийн хөхиүлэн дэмжинэ. Хадгалж буй арга хэлбэр, эх сурвалж, мэдээлэл үүссэн цаг хугацаанаас үл хамаарч төрийн байгууллагад авагдсан бүх төрлийн баримтыг энэ төрлийн мэдээлэл гэж үзнэ. Хүн бүр өөрт нь хамаарах мэдээллийг төрийн болон хувийн хэвшлийн ямар байгууллага, хувь хүн хянадаг, хянаж болохыг эргэлзээгүй мэдэх боломжтой байвал зохино. Мэдээлэл авах эрхийг хангахын тулд оролцогч улс нийтийн ашиг сонирхолд хамаарах өөрт байгаа мэдээллийг өөрийн санаачилгаар ил болгож, олон нийт хялбар, шуурхай, үр дүнтэй, бодитой танилцах боломжийг бүрдүүлэх ёстой юм.⁹ Гэвч манай улсын хувьд амьтан агнах, барих, усны нөөц, ойн баялаг, байгалийн ургамлын нөөц ашиглах болон эрдэс баялгийг хайх, ашиглах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл нийтэд ил тод биш байдаг.

Өөрөөр хэлбэл, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд иргэдийн бодитой оролцоог хангах, тэдэнд түгээх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, үзэл бодол, санал шаардлагаа илэрхийлэх боломж нөхцөлийг бодитоор бүрдүүлэх асуудал чухлаар хөндөгдсөөр байна. Иргэд байгаль орчин, ашигт малтмалын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх эсэх талаар бодитоор зөвлөлдөх эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг хайх, олж авах эрхийг Байгаль орчны тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулиар нарийвчлан зохицуулаагүй бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар байгаль орчны талаарх мэдээллийг хайх, хүлээн авах эрхийг тусгайлан хамгаалаагүй талаар судлаачид дурдсан.¹⁰ Тодруулбал,

⁶О.Мөнхсайхан, Р.Очирбал, *Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдал:Тулгамдсан асуудал, шийдэл ,тойм судалгаа*, УБ, 2021, 300 дахь тал

⁷Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар*, УБ, Адмон, 2023, 300 дахь тал

⁸Монгол Улсын Их Сургууль, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, *Үндсэн хууль манай сургуульд ҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар, сургалтын хөтөлбөр*, УБ, 2022, 140 дэх тал

⁹ Мөн тэнд 144 дэх тал

¹⁰О.Мөнхсайхан, Р.Очирбал, *Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдал:Тулгамдсан асуудал, шийдэл ,тойм судалгаа*, УБ, 2021, 319 дэх тал

НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар (№34 19, 2011): Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэхийн тулд оролцогч улсаас мэдээллийн эрх чөлөөний хууль батлах зэргээр мэдээлэл олж авахад зайлшгүй хэрэглэгдэх журмыг хуульчилбал зохино гэжээ.¹¹ Ийм үйл ажиллагаа нь мэдээлэл авах хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн төдийгүй олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд нийцүүлэх боловсруулсан, ойлгомжтой, тодорхой журмаар явбал зохино гэж зөвлөсөн байна.¹²

Иймд 2019 оны Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлтээр оруулсан Зургадугаар зүйл 2 дахь хэсэгт заасан *“Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрх”*-ийг бодитоор хэрэгжүүлэх нарийвчилсан журмыг хуульчлах шаардлагатай бөгөөд энэ нь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл юм. Тодруулбал, хуулийн төсөлд заасан

1. Байгалийн баялаг ашиглалтыг үндэсний ашиг сонирхолд нийцүүлэх;
2. Эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг дэмжих;
3. Олборлох үйлдвэрлэлийг байгальд сөрөг нөлөө багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлэх;
4. Байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанд олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлж, иргэний мэдэх эрхийг хангах;
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зорилго Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт болон дээд эрэмбийн эрх зүйн хэм хэмжээнд нийцэж байна.

Харин олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д заасан *“Байгалийн баялгийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх”* зорилт нь тус хуулийн зүйл заалттай хэрхэн уялдах буюу байгалийн баялгийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэхтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээ олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд байхгүй. Иймд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д заасан *“Байгалийн баялгийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх”* зорилтыг хэрэгжүүлэх эрх хэм хэмжээг тус хуулийн төслөөс **хасах нь зүйтэй**.

3.1.2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын зарчмын тухайд /хуулийн төслийн 5 дугаар зүйл/

Хүснэгт 9. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд заасан зарчмууд.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн зүйл, заалт	<p>5 дугаар зүйл. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын зарчим</p> <p><i>5.1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангахад Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:</i></p> <p><i>5.1.1. олборлох үйлдвэрлэл дэх төрийн байгууллага болон зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх;</i></p>
---	---

¹¹Азербайжан улсад өгсөн зөвлөмж (CCPR/C79/Add.38(1994))

¹²Монгол Улсын Их Сургууль, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, *Үндсэн хууль манай сургуульд* ҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар, сургалтын хөтөлбөр, УБ, 2022, 140 дэх тал

	<p>5.1.2.зөвшөөрөл эзэмшигч хариуцлагатай, ёс зүйтэй байх; 5.1.3.эрх тэгш, шударга өрсөлдөөнийг дэмжих; 5.1.4.мэдээлэл нь бүрэн, үнэн зөв, тогтмол шинэчлэгддэг байх.</p>
--	---

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгасан. Ингэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох *Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх* зарчмаас гадна дөрвөн зарчмыг тусгажээ.¹³

Зарчим гэдэг нь тухайн эрх зүйн харилцаа, зохицуулалтыг хангахад баримтлах хууль зүйн үндсэн чиглэмж, удирдамж, чиг шугам болдог.¹⁴ Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн үндсэн чиглэмж чиг шугам нь ил тод, нээлттэй, хариуцлагатай, ёс зүйтэй, эрх тэгш, шударга өрсөлдөөн дэмжих, бүрэн, үнэн зөв, тогтмол шинэчлэгдэхэд оршино.

Гэвч олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслөөр **ил тод, нээлттэй, хариуцлагатай, ёс зүйтэй, эрх тэгш, шударга өрсөлдөөн дэмжих, бүрэн, үнэн зөв, тогтмол шинэчлэх** зарчмыг ямар утгаар ойлгохыг тайлбарлаагүй. Тухайлбал, тогтмол шинэчлэх гэдгийг хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.6.3-т заасан тухайн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 5 өдрийн гэдгээр ойлгох уу, цаашлаад тогтмол шинэчлэх зарчимд хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.6.2, 12 дугаар зүйлийн 12.6.3 дахь заалт хамаарах уу гэдэг нь тодорхойгүй бөгөөд үүнд зайлшгүй хариулт өгөх байдлаар тус хуулийн зарчмуудыг нэг мөр тайлбарлах шаардлагатай байна. Эс бөгөөс ил тод, нээлттэй, хариуцлагатай, ёс зүйтэй, эрх тэгш, шударга өрсөлдөөн дэмжих, бүрэн, үнэн зөв, тогтмол шинэчлэгдэх зарчмуудыг хэрэглэхэд төвөгтэй байдлыг үүсгэх эрсдэлтэй.

Иймд, ил тод, нээлттэй, хариуцлагатай, ёс зүйтэй, эрх тэгш, шударга өрсөлдөөн дэмжих, бүрэн, үнэн зөв, тогтмол шинэчлэгддэг байх зарчмыг нэр томъёоны тодорхойлолт хэсэгт тайлбарлах, хуулийн төслийн аль бүлэгт, ямар хэм хэмжээгээр илэрч буй талаар хуулийн төслийн 5 дугаар зүйлд **нарийвчлан тусгах шаардлагатай**. Мөн Ирээдүй өв сангийн тухай хуулийн 6 дугаар зүйл заасантай¹⁵ төстэй байдлаар зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой хэм хэмжээ **нэмэх нь зүйтэй**. Учир нь ирээдүй өв сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.5-д тус сангийн хөрөнгийг удирдахад баримтлах зарчмыг хуульчилсан. Харин 6 дугаар зүйлд сангийн хөрөнгийг удирдахад баримтлах зарчмын агуулгыг дэлгэрүүлсэн тайлбарласан. Жишээлбэл, ирээдүй өв сангийн тухай хуулийн 5 дугаар 5.1.3-т сангийн хөрөнгийг зохистой удирдах зарчмыг заасан. Харин тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалтаас 6.3.11 дэх заалтад сангийн хөрөнгийг зохистой удирдах зарчмыг агуулгыг тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл ирээдүй өв сангийн тухай хуулийн 5 дугаар 5.1.3-т сангийн хөрөнгийг зохистой удирдах

¹³ 5.1.1.олборлох үйлдвэрлэл дэх төрийн байгууллага болон зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх;

5.1.2.зөвшөөрөл эзэмшигч хариуцлагатай, ёс зүйтэй байх;

5.1.3.эрх тэгш, шударга өрсөлдөөнийг дэмжих;

5.1.4.мэдээлэл нь бүрэн, үнэн зөв, тогтмол шинэчлэгддэг байх.

¹⁴ Д.Баярсайхан, *Эрх зүйн онол*, УБ, 2017, 224 дэх тал.

¹⁵ Ирээдүй өв сангийн тухай хууль, УБ, 2016, <https://legalinfo.mn/mn/detail/11707>

зарчмыг 13 агуулгаар тайлбарласан. Энэ нь практикт 5 дугаар 5.1.3-т сангийн хөрөнгийг зохистой удирдах зарчмыг нэр мөр ойлгох боломжийг бүрдүүлж байна.

Түүнчлэн, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга /цаашид ОУИТБС/-ыг 2002 онд Йохансбургт болсон Тогтвортой хөгжлийн асуудлаарх дэлхийн дээд хэмжээний уулзалтаас анх гаргасан юм. Энэ нь Засгийн газрууд, иргэний нийгмийн байгууллагууд, хөрөнгө оруулагчдын дэлхий нийтийн эвслийг байгалийн баялгаас олж буй орлогын төлөлт ба хүлээн авалтыг илүү ил тод болгох зорилготой.¹⁶ ОУИТБС-ыг хэрэгжүүлэх тулгын чулуу нь ОУИТБС зарчмууд юм.¹⁷ Тодруулбал, ОУИТБС-ын зарчмуудыг 2003 оны 6 дугаар сард Лондонд болсон ОУИТБС-ын анхдугаар бага хурлаар улс орнууд, компаниуд, иргэний нийгмийн байгууллагууд, хөрөнгө оруулагчдын янз бүрийн бүлгүүдийн зүгээс олборлох салбар дахь төлбөр, орлогуудын ил тод байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн 12 зарчмуудыг хүлээн зөвшөөрсөн билээ.¹⁸

Хүснэгт 10. ОУИТБС-ын зарчмууд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуульд тусгасан байдал.

№	ОУИТБС-ын зарчмууд	Тайлбар
Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт тусгалаа олсон ОУИТБС-ын зарчмууд		
1.	Байгалийн баялгийг зохистой ашиглах нь тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулдаг эдийн засгийн тогтвортой өсөлтийн чухал хөдөлгүүр байх ёстой боловч зөв удирдаж чадахгүй бол эдийн засаг, нийгэмд сөрөг үр дагаврыг бий болгодог гэдэгт бид итгэдэг.	Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт тусгалаа олсон. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд эл зарчим байхгүй.
2.	Байгалийн баялгийн баялгийг тухайн улсын иргэдийн эрх ашгийн төлөө удирдах нь тусгаар тогтносон засгийн газрын мэдэлд байх нь тэдний үндэсний хөгжлийн ашиг сонирхолд нийцэж байгааг бид баталж байна.	Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт тусгалаа олсон. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд эл зарчим байхгүй.
3.	Баялгийн олборлолтын үр өгөөж нь олон жилийн турш орлогын урсгал хэлбэрээр гарч ирдэг бөгөөд үнэ ханшаас ихээхэн хамааралтай болохыг бид хүлээн зөвшөөрдөг.	Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт тусгалаа олсон. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд эл зарчимд байхгүй.

¹⁶Нээлттэй нийгэм форум, *Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга: Олон Улсын зөвлөх бүлгийн тайлан*, УБ, 2006, 10 дахь тал, https://forum.mn/uploads/site/1126/res_mat/OlborlohUildverlelSanaachilga.pdf, [Сүүлд үзсэн:2024.02.29]

¹⁷ The Extractive Industries Transparency Initiative (EITI) principles, <https://eiti.org/documents/eiti-principles>, [Сүүлд үзсэн:2024.02.29]

¹⁸ The Extractive Industries Transparency Initiative standard, 2023, <https://eiti.org/sites/default/files/2023-06/2023%20EITI%20Standard.pdf>, [Сүүлд үзсэн:2024.02.29]

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд зарчим, болон хэм хэмжээ байдлаар тусгалаа олсон ОУИТБС-ын зарчмууд		
4.	Засгийн газрын орлого, зарлагын талаарх олон нийтийн ойлголт нь цаг хугацааны явцад олон нийтээр хэлэлцүүлж, тогтвортой хөгжлийн оновчтой, бодит хувилбаруудыг сонгоход тустай гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд зарчим гэхээс илүүтэй хэм хэмжээ байдлаар тусгасан.
5.	Олборлох үйлдвэрлэлийн салбарт төр, компаниуд ил тод байх нь чухал бөгөөд төрийн санхүүгийн удирдлага, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг бид онцолж байна.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд олборлох үйлдвэрлэлийн салбарт “ил тод байх” нь зарчмыг тусгасан. Харин төрийн санхүүгийн удирдлага, хариуцлагыг нэмэгдүүлэх нь тус хуулийн төсөлд байхгүй
6.	Илүү ил тод байдлыг хангахын тулд гэрээ, хууль тогтоомжийг хүндэтгэх хүрээнд тогтоох ёстой гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд зарчим гэхээс илүүтэй хэм хэмжээ байдлаар зохицуулсан.
7.	Санхүүгийн ил тод байдал нь дотоод, гадаадын шууд хөрөнгө оруулалтын орчинг сайжруулж байгааг бид хүлээн зөвшөөрч байна.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд зарчим гэхээс илүүтэй хэм хэмжээ байдлаар тусгасан. Тодруулбал, тус хуулийн зорилт хэсэгт “эдийн засгийн тогтвортой өсөлт хөгжлийн дэмжих” агуулгыг багтсан.
8.	Бид олон нийтийн амьдрал, төрийн үйл ажиллагаа, бизнест ил тод байдал, хариуцлагын өндөр стандартыг дэмжихийг зорьж байна.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн “5.1.2-д зөвшөөрөл эзэмшигч хариуцлагатай” байх буюу зарчим болгож зохицуулсан.
9.	Төлбөр, орлогыг ил тод болгоход өргөн хүрээнд тууштай, үр дүнтэй арга барил шаардлагатай гэж бид үзэж байгаа бөгөөд үүнийг хийх, ашиглахад хялбар.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд зарчим гэхээс илүүтэй хэм хэмжээ байдлаар тусгасан.

10.	Тухайн улс орны төлбөр тооцоог ил тод болгоход тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй олборлох үйлдвэрлэлийн бүх компаниуд хамрагдах ёстой гэж бид үзэж байна.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн “5.1.1-д олборлох үйлдвэрлэл дэх төрийн байгууллага болон зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа”-г хамруулахаар зохицуулжээ.
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд тусгаагүй ОУИТБС-ын зарчмууд		
11.	Төсвийн орлогын урсгал, төсвийн зарцуулалтыг хэрхэн зохицуулах талаар төрөөс нийт иргэдийн өмнө хариуцлага хүлээх зарчим, практикт бид итгэдэг.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд тусгаагүй.
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд хамаарахгүй ОУИТБС-ын зарчмууд		
12.	Шийдлийг эрэлхийлэхдээ засгийн газар, тэдгээрийн агентлагууд, олборлох аж үйлдвэрийн компаниуд, үйлчилгээний компаниуд, олон талт байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон төрийн бус байгууллагууд зэрэг бүх оролцогч талууд чухал бөгөөд хамааралтай хувь нэмэр оруулах ёстой гэдэгт бид итгэдэг.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд хамаарахгүй ОУИТБС-ын зарчим

Хүснэгт 10-аас үзвэл, ОУИТБС-ын 12 зарчмын 7 зарчмыг олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд зарчим болон хэм хэмжээ болгосон. ОУИТБС-ын 12 зарчмын 3 зарчим олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд бус Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт хуульчилсан. Харин ОУИТБС-ын 12 зарчмаас 1 зарчмыг нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд зохицуулаагүй бол УИТБС-ын 12 зарчмаас 1 зарчим нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд хамаарах эсэх нь эргэлзээтэй байна.

Иймд ОУИТБС-ын Төлбөр, орлогыг ил тод болгоход өргөн хүрээнд тууштай, үр дүнтэй арга барил шаардлагатай гэж үздэг бөгөөд үүнийг хийх, ашиглахад хялбар байх зарчмыг олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд тусгах **нь зүйтэй.**

3.1.3. Үндэсний зөвлөлийн тухайд /хуулийн төслийн 14 дүгээр зүйл /

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлд Үндэсний зөвлөлд хамаарах эрх зүйн орчныг дараах байдлаар зохицуулжээ. Тодруулбал, 14 дүгээр зүйлийн 14.1-д “*Үндэсний зөвлөл*”-ийн чиг үүрэг, 14 дүгээр зүйлийн 14.2-д “*Үндэсний зөвлөл*”-ийн бүрэлдэхүүн, 14 дүгээр зүйлийн 14.3-д “*Үндэсний зөвлөл*”-ийн бүрэн эрхийн хугацаа, 14 дүгээр зүйлийн 14.4-д “*Үндэсний зөвлөл*”-ийн бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах, 14 дүгээр зүйлийн 14.5-д “*Үндэсний зөвлөл*”-ийг томилох журам, 14 дүгээр зүйлийн 14.6-д “*Үндэсний зөвлөл*”-ийн даргыг Засгийн

газарт санал болгох, 14 дүгээр зүйлийн 14.7-д “Үндэсний зөвлөл”-ийн бүрэн эрх, 14 дүгээр зүйлийн 14.8-д “салбар зөвлөл”, 14 дүгээр зүйлийн 14.9-д “салбар зөвлөл”-ийн ажиллах журам, бүтэц, чиг үүрэг, бүрэлдэхүүн, 14 дүгээр зүйлийн 14.10-д “салбар зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг томилж, батлуулахаар аймгийн засаг дарга Үндэсний зөвлөлд санал хүргүүлэх зэрэг болно.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн нэг чухал зорилт нь байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих боломжийг бүрэлдүүлэх юм. Энэхүү зорилтод хэрэгжүүлэх чухал хөшүүргэ нь Үндэсний зөвлөл юм. Энэ ч утгаараа Үндэсний зөвлөл нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, хяналт тавих, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилтийг Засгийн газарт тайлагнах чиг үүрэгтэй.

Хүснэгт 11. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд заасан Үндэсний зөвлөлд хамаарах хэм хэмжээ

<p>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн зүйл, заалт</p>	<p>14.2. Үндэсний зөвлөл нь Хүний эрхийн үндэсний комисс, Авлигатай тэмцэх газар, байгаль орчин, геологи, уул уурхай, санхүү, төсөв, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх бусад холбогдох төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдэх ба бүрэлдэхүүн нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн харьцааг тэнцвэртэй, тэгш оролцоог хангасан байна.</p> <p>14.3. Үндэсний зөвлөл дэх зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг нээлттэй сонгон шалгаруулж, 3 жилийн хугацаагаар томилно.</p>
--	--

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэм хэмжээнээс үзвэл Үндэсний зөвлөл дараах төлөөллөөс бүрдэхээр заажээ. Үүнд:

- Хүний эрхийн үндэсний комисс,
- Авлигатай тэмцэх газар,
- Байгаль орчин,
- Геологи,
- Уул уурхай,
- Санхүү,
- Төсөв,
- Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,

- Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх бусад холбогдох төрийн байгууллага,
- Зөвшөөрөл эзэмшигч,
- Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл байхаар заажээ. Гэвч энэхүү хэм хэмжээ “байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих боломж” зорилгод нийцэхийн тулд дараах асуудлыг тодруулах зайлшгүй шаардлага үүсэж байна.

Нэгдүгээрт, Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд багтах төрийн захиргааны төв байгууллагыг тодорхой болгох. Өөрөөр хэлбэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2-д зааснаас үзвэл төрийн захиргааны 6 төв байгууллагыг жагсаасан.¹⁹ Гэвч ийнхүү жагсаан бичсэн зарим төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх давхардаж байна. Тодруулбал, 1993 оны Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *Монгол Улсын яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн* гээд тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д ерөнхий чиг үүргийн дөрөв, чиглэлийн арван нэг нийт арван зургаан төрийн захиргааны төв байгууллага байхаар хуульчилсан.²⁰

Хүснэгт 12. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд заасан Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд орох төрийн захиргааны төв байгууллага ба Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан төрийн захиргааны төв байгууллага, түүний эрхлэх асуудлын харьцуулалт

№	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд заасан Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд орох төрийн захиргааны төв байгууллага	Монгол Улсын засгийн газрын тухай хуульд заасан төрийн захиргааны төв байгууллага, түүний эрхлэх асуудал
1.	Байгаль орчин,	Байгаль орчин, аялал жуулчлалын яам;
2.	Геологи,	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;
3.	Уул уурхай,	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;
4.	Санхүү,	Сангийн яам;
5.	Төсөв,	Сангийн яам;

¹⁹ Байгаль орчин, геологи, уул уурхай, санхүү, төсөв, хууль зүйн асуудал

²⁰ Монгол Улсын засгийн газрын тухай хууль, УБ, 1993, <https://legalinfo.mn/mn/detail/344>

6.	Хууль зүйн асуудал	Хууль зүй, дотоод хэргийн яам;
----	--------------------	--------------------------------

Дээрх хүснэгтээс үзвэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2-д заасан 6 төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх асуудлыг дөрвөн төрийн захиргааны төв байгууллагын эрхэлж байна. Иймд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалтыг “Үндэсний зөвлөл нь Хүний эрхийн үндэсний комисс, Авлигатай тэмцэх газар, айгаль орчин, геологи уул уурхай, санхүү төсөв, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж таслалыг **арилгаж өөрчлөх нь зүйтэй байна.**

Хоёрдугаарт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2-д *“төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх бусад холбогдох төрийн байгууллага”* гэж ямар төрийн байгууллагыг хэлж байгаа, цаашлаад тус байгууллагаас Үндэсний зөвлөлд байх орон тоог тодорхой болгох **шаардлагатай.**

Гуравдугаарт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2-д төр, хувийн хэвшил, иргэний байгууллагаас Үндэсний зөвлөлд сонгогдох гишүүдийн тоог заагаагүй. Тодруулбал, тус хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2-д *“...төр, хувийн хэвшил, иргэний байгууллагын төлөөллийн харьцааг тэнцвэртэй, тэгш оролцоог хангасан байна”* гэж заасан. Төлөөллийн харьцаа тэнцвэртэй, тэгш оролцоотой байна гэдэг нь юун түрүүнд төр, хувийн хэвшил, иргэний байгууллагаас Үндэсний зөвлөлд сонгогдох гишүүний тоо ижил байхыг олгоно. Үүнийг 2023 оны Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-35.1.5 дахь заалтаас харж болно. Уг заалтад нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийг төрийн захиргааны төв байгууллага, үйлдвэрчний эвлэлээс гурван хүн, ажил олгогчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагаас гурван хүнээс бүрдэхээр хуульчилсан байна.²¹ Иймд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2-д төр, хувийн хэвшил, иргэний байгууллагаас Үндэсний зөвлөлд **сонгогдох гишүүдийн тооны харьцааг тэнцвэртэй, байдлаар тусгах шаардлагатай.**

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.3-т Үндэсний зөвлөл дэх зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг нээлттэй сонгон шалгаруулж, 3 жилийн хугацаагаар томилохоор заажээ. Уг заалтаас Үндэсний зөвлөлд дэх зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүрэн эрхийн хугацааг ямар үндэслэлээр 3 жилийн хугацаанд заасан нь тодорхойгүй. Харин Үндэсний зөвлөл дэх төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийн хувьд сонгуулийн дөрвөн жилээр томилохоор байна.

Энэ нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2-т *“...бүрэлдэхүүн нь төр хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн харилцааг тэнцвэртэй, тэгш оролцоог хангана”* гэж заасантай зөрчилдөж байна. Тодруулбал, тус хуулийн төслийн **Байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанд олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлж, иргэний**

²¹ Нийгмийн даатгалын ерөнхий хууль, УБ, 2023, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760148379551>

мэдэх эрхийг хангах зорилттой нийцэхгүй. Учир нь төрийн хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг ижил бүрэн эрхийн хугацаатай сонгохгүйгээр харилцан тэнцвэртэй, тэгш оролцоо, цаашлаад олон нийтийн хяналт бүрдэх боломжгүй.

Түүнчлэн, 2023 оны Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар засгийн газар, үйлдвэрчний эвлэл, ажил олгогч байгууллагаас бүрдсэн нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийг байгуулахаар хуульчилсан бөгөөд бүрэн эрхийн хугацааг зургаан жилийн хугацаагаар томилохоор заасан.²² Үүнтэй адил төрийн албаны зөвлөл, болон шүүгчийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг 6 жил байхаар хуульчилсан байдаг..

Иймд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.3-т Үндэсний зөвлөл дэх зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг 3 жилийн хугацаанд томилох заасныг байгаа **өөрчлөх нь зүйтэй**. Ингэхдээ Үндэсний зөвлөл дэх төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хугацаатай адил болгох, эсхүл бусад зөвлөлийн адилаар 6 жилийн хугацаатай сонгож болгох нь зүйтэй.

²² Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх заалт , УБ, 2023, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760148379551>

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хүснэгт 13. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
2.	Практикт хэрэгжих байдлыг баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар хэрэгжих эсэхийг судлах	Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.

3.2.1. Үндэсний зөвлөлийн чиг үүргийн тухайд /хуулийн төслийн 14 дүгээр зүйл 14.1/

Хүснэгт 14. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлт болон Үндэсний зөвлөлийн эрх зүйн хэм хэмжээ 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
3.	Үндэсний зөвлөлийн чиг үүрэг нь практикт хэрэгжих боломжтой эсэх;	14 дүгээр зүйл. Үндэсний зөвлөл 14.1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, хяналт тавих, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилтийг Засгийн газарт тайлагнах чиг үүрэг бүхий, төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн Үндэсний зөвлөл нь Ерөнхий сайдын дэргэд ажиллана.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1-д Үндэсний зөвлөлийн чиг үүргийг **нэгдүгээрт**, тус хуулийн хэрэгжилтийн хангах, **хоёрдугаарт**, олборлох ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, **гуравдугаарт**, мөн хуулийн төслийн хэрэгжилтэд хяналт тавих, **дөрөвдүгээрт**, олборлох ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг засгийн газар тайлагнах гэж үндсэн дөрвөн агуулгыг тусгасан.

Өөрөөр хэлбэл Үндэсний зөвлөл нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.5-д заасан олборлох үйлдвэрлэлийн нээлттэй мэдээллийн санг хариуцах ажиллах юм. Тодруулбал, тус хуулийн 6.1.1-д “Эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагааны мэдээллийн санд 15 төрлийн 78 мэдээллийг, 6 дугаар зүйлийн 6.1.2-д заасан Үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглах үйл ажиллагааны мэдээллийн санд 16 мэдээллийг, 6 дугаар зүйлийн 6.1.3-д Ойн баялаг ашиглах үйл ажиллагааны мэдээллийн санд 24 мэдээллийг, 6 дугаар зүйлийн 6.1.4-д Амьтан барих, агнах үйл ажиллагааны мэдээллийн санд 25 мэдээллийг, 6 дугаар зүйлийн 6.1.5-д Байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагааны мэдээллийн санд 8 мэдээллийг ил тод, нээлттэй болгохоор хуулийн төсөлд заажээ.

График 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслөөр ил тод, нээлттэй болгох мэдээллийн тоо



Дээрх хүснэгтээс үзвэл, Үндэсний зөвлөл нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд заасан олборлох үйлдвэрлэлийн нээлттэй мэдээллийн сан буюу 5 төрлийн мэдээллийн санд хамаарах 151 мэдээллийг ил, тод нээлттэй болгох ажлыг зохион байгуулах, түүнийг хэрэгжилтэд хяналт тавих юм. Ийнхүү олборлох үйлдвэрлэлийн нээлттэй мэдээллийн санд 151 мэдээллийг байршуулах практикт хэрэгжиж буй бусад ил, тод нээлттэй мэдээллийг давхцуулахгүйгээр нэгтгэх шаардлага зүй ёсоор бий болно. Өөрөөр хэлбэл, байгаль орчны мэдээллийн сан <https://eic.mn/land/>, ОУИТБС-ийн цахим тайлангийн систем зэргийг дурдаж байна.

Түүнчлэн, Монгол Улс олборлох салбарын үйл ажиллагаанд ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх ажлыг шат дараалалтай хэрэгжүүлж ирсэн бөгөөд нийгэмд үүсээд буй хэрэгцээ шаардлагыг тооцохын зэрэгцээ олон улсын шилдэг туршлагаудыг нэвтрүүлэх ажлыг ч эртнээс хийж эхэлсэн билээ. Үүний нэг жишээ нь олборлох салбарын засаглалыг сайжруулах, төр болон хувийн хэвшлийг хариуцлагажуулах, улмаар уг салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой, өдгөө дэлхийн 52 улс орныг эгнээндээ элсүүлсэн ОУИТБС-д 2007 онд нэгдэн орсон явдал юм. Цаашлаад 2013 онд Нээлттэй засаглалын түншлэл (НЗТ)-д нэгдэж, төрийн үйл ажиллагааг ухаалаг, нээлттэй, ил тод болгох, төрийн нэгдсэн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх алхмуудыг хэрэгжүүлж байгаа билээ.²³

Энэ ч утгаараа 2006 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг байгуулан мөн оны 05 дугаар сарын 12-ны өдөр анхны хурлыг зохион байгуулжээ.²⁴

²³ Нээлттэй нийгэм форум, *Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хэрэгцээ, шаардлага, урьдчилсан тандан*, Судалгааны тайлан, УБ, 2020, <https://forum.mn/product/152515>, [Сүүлд үзсэн:2024.02.29]

²⁴ Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга, <https://www.eitimongolia.mn/p/3>, [Сүүлд үзсэн:2024.02.29]

Үүнээс хойш Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл 21 удаа хуралдаж, хуралдаанаар хэлэлцсэн асуудал, түүнийг тэмдэглэлийг нээлттэй, ил тод байдлаар байршуулжээ.²⁵

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд 28 гишүүн ажиллаж байна. Үүний 9 гишүүн нь төрийг, 9 гишүүн нь хувийн хэвшлийг үлдсэн 10 гишүүн нь төрийн бус байгууллагыг төлөөлж байна. Эдгээр гишүүд нь хамгийн дээд тал нь 18 жил, хамгийн доод тал нь 3 жил 7 сарын хугацаанд уг зөвлөлийн гишүүнээр ажиллажээ.

Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга цахим хуудсанд ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 03, 2015 оны 06 дугаар сарын.04, 2015 оны 12 дугаар сарын 18, 2016 оны 12 дугаар сарын 20, 2017 оны 12 дугаар 21-ний өдрийн хуралдааны ирцийг мэдээллийг байршуулжээ. Уг 5 хуралдааны ирцийн мэдээллээс үзвэл, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдаан нь ирц дунджаар 65.9 хувьтай байсан. ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдааны хамгийн өндөр хуралдааны ирц нь тус зөвлөлийн 2015.01.03-ын өдрийн хуралдаан бөгөөд 30 хүнээс 25 хүн ирж, хуралдааны ирц 83 хувьтай байжээ. Харин ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдааны хамгийн бага хуралдааны ирц 2015.06.04-ний өдрийн хуралдаан бөгөөд 30 хүнээс 15 хүн ирж, хуралдааны ирц 50 хувьтай байжээ.

Түүнчлэн, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 03, 2015 оны 06 дугаар сарын.04, 2015 оны 12 дугаар сарын 18, 2016 оны 12 дугаар сарын 20, 2017 оны 12 дугаар 21-ний өдрийн хуралдааны ирцийн мэдээллээс үзвэл төрийн байгууллагын төлөөллийн хувьд хуралдаандаа ирэхгүй байх эсхүл орлож хүн явуулах хандлага ажиглагдаж байна.

Дээрхээс үзвэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан Үндэсний зөвлөлд хамаарах эрх зүйн хэм хэмжээ нь сүүлийн 18 гаруй жилийн хугацаанд практик хэрэгжиж иржээ. Гэхдээ жилд 1, 2 удаа хуралддаг, төрийн байгууллагын төлөөлөл тэр бүр оролцдоггүй зэрэг хүндрэлүүд байгааг анхаарах шаардлагатай. Тодруулбал, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 2006 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирсэн боловч ОУИТБС-ын цахим сайтын мэдээлэл 2019 оноос хойш шинэчлэгдээгүй, мэдээлэл хэт ерөнхий зэрэг **хүндрэл байгааг дурдах нь зүйтэй.**

²⁵Мөн тэнд

3.2.2. Иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлын тайлангийн тухайд /хуулийн төслийн 19 дүгээр зүйл 14.1/

Хүснэгт 15. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлт болон Иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлын тайлангийн талаарх эрх зүйн хэм хэмжээ

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
1.	Иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлын тайлангийн талаарх зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;	<p>19 дүгээр зүйл. Иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлын тайлан</p> <p><i>19.1.Зөвшөөрөл эзэмшигчээс хандив, тусламж, дэмжлэг, урамшуулал зэрэг болон бусад аливаа хэлбэрээр санхүүжилт авсан иргэний нийгмийн байгууллага энэ хуулийн 16.1.3-т заасан ил тод байдлын тайланг жилээр гаргаж дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор холбогдох мэдээллийн санд цахимаар оруулна.</i></p>

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн төслийн зохицуулалт нь тодорхой тохиолдолд үйлчлэх, бодит байдал дээр хэрэгжих эсэхийг үнэлнэ. Энэхүү хүрээнд хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан зохицуулалтад дүн шинжилгээ хийлээ.

Төслийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг заасан зохицуулалтын практик хэрэгжилтийг судлахаас өмнө тус зохицуулалт нь найруулга зүйн хувьд алдаатай байгааг дурдах нь зүйтэй. Учир нь тус хуулийн төслийн 19.1-д “...Зөвшөөрөл эзэмшигчээс хандив, тусламж, дэмжлэг, урамшуулал зэрэг болон бусад аливаа хэлбэрээр санхүүжилт авсан иргэний нийгмийн байгууллага энэ хуулийн 16.1.3-т заасан ил тод байдлын тайланг жилээр гаргаж дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор холбогдох мэдээллийн санд цахимаар оруулна...” гэж заасан. Энэхүү заалтад “**зэрэг, болон**” гэх холбох үгсийг нэг дор бичсэн нь найруулга зүйн алдааг бий болгож байна. Мөн “...энэ хуулийн 16.1.3-т заасан...” гэх агуулга байхгүй байсан ч тус зохицуулалтын ач холбогдол алдагдахгүй байна. Иймд төслийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг өөрчлөн найруулах нь зүйтэй.

Энэхүү зохицуулалт нь хэдийгээр найруулга зүйн алдаатай боловч тус зохицуулалтын практикт хэрэгжих боломжийг судлан үзэх шаардлагатай. Учир нь энэхүү хуулийн төслийн хүрээнд 3 субъект буюу **төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллага** олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг гаргахаар тусгагдсан.

Төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч хоёрын хувьд хуулийн төслийн 12 дугаар зүйлд заасан мэдээллийн сангийн мэдээлэл нийлүүлэгчид хамаарах бөгөөд **иргэний нийгмийн байгууллагын** хувьд мэдээлэл нийлүүлэгчийн статусгүй байна.

Хуулийн төсөлд тусгаснаар мэдээлэл нийлүүлэгч нь:

- Энэ хуульд заасан мэдээллийн өөрт хамаарах суурь буюу анхан шатны тайлан, мэдээллийг зөвшөөрөл эзэмшигч /Төслийн 12.2/

- түүнийг нэгтгэсэн мэдээллийг холбогдох төрийн байгууллага хариуцаж мэдээллийн санд оруулна. /Төслийн 12.2/
- мэдээлэл, түүнийг хариуцах мэдээлэл нийлүүлэгчийг холбогдох мэдээллийн санд бүртгэнэ. /Төслийн 12.3/
- мэдээлэл нийлүүлэгч нь мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулах үүрэг хүлээнэ. /Төслийн 12.4/
- мэдээлэл бий болсноос хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох мэдээллийн санд баталгаажуулан оруулах, тухай мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 5 өдрийн дотор өөрчлөх /Төслийн 12.6.3/
- Цахим хэлбэрээр эрх бүхий байгууллагад илгээсэн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг цахим гарын үсгээр баталгаажуулах /Төслийн 12.8/
- Баталгаажуулах боломжгүй тохиолдолд цаасан хэлбэрээр хүргүүлнэ. /Төслийн 12.8/
- Мэдээллийн санд оруулсан мэдээлэл, тайланг оруулснаас хойш 3 сарын дотор багтаан засаж залруулж болно. /Төслийн 12.9/ гэж тус тус заажээ.

Дээрхээс үзвэл, төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигчийн хувьд мэдээллийн санд мэдээлэл оруулахдаа мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулна. Харин иргэний нийгмийн байгууллагын хувьд мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулах зохицуулалт байхгүй. Өөрөөр хэлбэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй хэрэглэгч мэдээллийн санд мэдээлэл оруулах боломжгүй байна. Гэтэл төслийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт иргэний нийгмийн байгууллага ил тод байдлын тайлангаа мэдээллийн санд цахимаар оруулахаар тусгасан зохицуулалтыг **практикт хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.**

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэх мөн логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгах шаардлагатай. Мөн хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ийг баримталсан эсэхийг тусгайлан шалгана. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн зохицуулалт нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхэд дараах байдлаар дүн шинжилгээ хийсэн болно.

Хүснэгт 16 . Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1.	Төслийн 3.1.Энэ хууль нь амьтан агнах, барих, усны нөөц, ойн баялаг, байгалийн ургамлын нөөц ашиглах, эрдэс баялаг хайх, ашиглах үйл ажиллагааны мэдээлэл, гэрээ, хэлэлцээрийг нээлттэй байлгах, мэдээллийн сан бүрдүүлэх, ил тод байдлыг хангахтай холбогдох харилцаанд үйлчилнэ.	Төслийн 6.1 дүгээр зүйлд заасан олборлох үйлдвэрлэлийн нээлттэй мэдээллийн сангийн төрлийг төслийн 3.1-д заасан зохицуулалттай уялдуулж дарааллыг өөрчилснөөр тус зохицуулалт илүү ойлгомжтой болох боломжтой байна.	Төслийн 3.1-д заасан зохицуулалтын дараалалтай уялдуулан төслийн 6.1.1-6.1.5-д заасан мэдээллийн сангийн төрлийн дарааллыг өөрчлөх. Ийнхүү өөрчилснөөр төслийн 6.2-д заасан зохицуулалтад өөрчлөлт орно.
2.	Төслийн 3.1.1-д “...эрдэс баялаг хайх, ашиглах үйл ажиллагааны мэдээлэл, гэрээ, хэлэлцээрийг нээлттэй байлгах, мэдээллийн сан бүрдүүлэх...”	Төслийн 3.1.1-д эрдэс баялаг хайх, ашиглах үйл ажиллагааг гэснийг төслийн 6.1.1-д заасан эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа гэсэнтэй уялдуулан нэг мөр болгох.	Тус нэр томъёог нэг мөр болгох.
3.	Төслийн 5.1.4.мэдээлэл нь бүрэн, үнэн зөв, тогтмол шинэчлэгддэг байх.	Төслийн 5.1.4-т мэдээлэл нь бүрэн гэсэн нь хэт ерөнхий байна.	Төслийн 5.1.4-т “...мэдээлэл нь бүрэн...” гэсний дараа “...гүйцэд...” гэж нэмж оруулах.
4.	Төслийн 12.6.1-д “...цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлэх...”	Төслийн 12.6.1-д “...баталгаажуулан...” алдаатай бичигдсэн засах.	Төслийн 12.6.1-д “...баталгаажуулан...” гэх.

5.	Төслийн 6.8.1.Энэ хуульд заасан нээлттэй мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан авах, бүртгэх, хяналт тавих.	Төслийн 6.8.1-д нээлттэй мэдээлэл гэх ойлголт байх боловч тус ойлголтыг энэ хуульд тодорхойлоогүй байна. Энэхүү ойлголтыг НМИТБТХ-ийн 7.1-д тодорхойлсон байна. Иймд энэхүү тодорхойлолтыг харгалзан хуулийн нэр томьёо хэсэгт нэмж оруулж болох юм.	Тус хуулийн төслийн 4 дүгээр зүйлд заасан хуулийн нэр томьёоны тодорхойлолт хэсэгт нээлттэй мэдээлэл гэх ойлголтыг нэмэх.
6.	Төслийн 7.1.4 дэх заалт	Төслийн 7.1.4-д зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг дугаарласан. Ингэхдээ 7.1.4 а-г орхигдуулсан.	Төслийн 7.1.4 б дэх заалтыг 7.1.4а гэж өөрчлөх.
7.	Төслийн 7.1.4г. <i>Ашигт малтмалын тухай хуулийн 35.4-т заасан комиссын шийдвэр.</i>	АМТХ-ийн 35.4-т <i>"...Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон комисс уурхайг хүлээн авсны дараа ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг уурхайг ажиллуулж эхэлнэ..."</i> гэж заасан нь төслийн 7.1.4г-д заасан комиссын шийдвэр гэх ойлголтод хамаарахгүй байна.	Иймд төслийн 7.1.4г дэх заалтыг өөрчлөн найруулах.
8.	Төслийн 7.1.8а, 7.1.13в, 7.1.14а дэд заалт.	Төслийн 17 заалтад эрдэс баялаг олборлох үйлдвэрлэл гэж, 3 заалтад эрдэс баялгийн олборлох үйлдвэрлэл гэж ижил агуулга бүхий нэг нэр томьёог ялгамжтай байдлаар бичжээ.	Иймд тус ойлголтыг нэг мөр болгох. Үүнийг хүснэгт 17-оос дэлгэрэнгүй харна уу.
9.	Төслийн 10 дугаар зүйл. Төслийн 10.1, 10.1.1 дэх заалт.	Төслийн 10 дугаар зүйл, 10.1 дэх хэсэг, 10.1.1 дэх заалтад <i>"...амьтан барих, агнах..."</i> гэж тусгасан байна. Төслийн бусад зүйл, хэсэгт <i>"...амьтан агнах, барих..."</i> гэж тусгажээ.	Төслийн 10 дугаар зүйл, 10.1 дэх хэсэг, 10.1.1 дэх заалтын <i>"...амьтан барих, агнах..."</i> гэснийг <i>"...амьтан агнах, барих..."</i> гэж өөрчлөх.
10.	Төслийн 10.1.15-д <i>"...улс, орон нутгийн болон иргэн, хуулийн этгээдийн захиалга..."</i> гэж.	Төслийн 10.1.15-д <i>"...улс..."</i> гэж тусгасан нь учир дутагдалтай байна.	Төслийн 10.1.15-д заасан <i>"...улс..."</i> гэснийг <i>"...төр..."</i> гэж өөрчлөх.
11.	Төслийн 11.1.5.Улсын тэмдэгийн хураамжийн тухай хуулийн 21.1.16, 21.1.17-д заасан төлбөр төлөлтийн жилийн мэдээлэл; 11.1.6.Улсын тэмдэгийн хураамжийн тухай хуулийн 21.1.13, 21.1.15, 21.1.18-д заасан	Төслийн 11.1.5, 11.1.6-д Улсын тэмдэгийн хураамжийн тухай хуулийн 21.1.13-21.1.18-д заасан хураамж төлсөн жилийн мэдээллийн талаар зохицуулсан зохицуулалтыг 2 тусад нь ялгамжтай байдлаар салгаж зохицуулсныг нэгтгэн нэг зохицуулалт болгох нь зүйтэй.	Төслийн 11.1.5, 11.1.6 дахь заалтыг нэгтгэх.

	<i>төлбөр төлөлтийн жилийн мэдээлэл;</i>		
12.	Төслийн 12.4. Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан холбогдох мэдээллийн сан хариуцагчаас мэдэгдсэнээр заасан хугацаанд мэдээлэл нийлүүлэгч нь мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулах үүрэг хүлээнэ.	Төслийн 12.4-т "...холбогдох мэдээллийн сан хариуцагчаас мэдэгдсэнээр заасан хугацаанд мэдээлэл нийлүүлэгч нь мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулах үүрэг хүлээнэ..." гэж заасан нь найруулга зүйн хувьд ойлгомжгүй байна.	Төслийн тус зохицуулалтыг өөрчлөн найруулах.
13.	Төслийн 12.4. Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан холбогдох мэдээллийн сан хариуцагчаас мэдэгдсэнээр заасан хугацаанд мэдээлэл нийлүүлэгч нь мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулах үүрэг хүлээнэ. Төслийн 12.6. Мэдээлэл нийлүүлэгч нь дараах үүрэг хүлээнэ:	Төслийн 12.6-д мэдээлэл нийлүүлэгчийг үүргийг тусгасан бөгөөд төслийн 12.4 дэх хэсэгт мөн мэдээлэл нийлүүлэгчийн үүргийг агуулсан зохицуулалтыг тусгасан байна. Иймд тус зохицуулалтыг төслийн 12.6 дахь хэсэгт нэмж оруулах, мөн төслийн 12.7-д мэдээлэл нийлүүлэгчийн ганцхан эрхийг тусгасан байна. Үүнийг төслийн 12.6 дахь хэсэгт нэгтгэж болох юм.	Төслийн 12.4, 12.7 дахь хэсгийн зохицуулалтыг төслийн 12.6 дахь хэсэгт оруулах. Мэдээлэл нийлүүлэгчийн эрхийг энэ хэсэгт нэгтгэсэнээр төслийн 12.6. Мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг гэж өөрчилж болох юм.
14.	Төслийн 12.6.1-д "...өөрийн хариуцах мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг ил тод байлгах, энэ хуульд заасан журам, шаардлага, хугацаа, маягтын дагуу мэдээллийн санд бүрэн, үнэн зөв оруулах..."	Төслийн 12.6.1-д "...олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг ил тод байлгах..." гэж ил тод гэх үгийг 2 удаа даван бичсэн нь нь найруулга зүйн хувьд алдаатай байна.	Тус зохицуулалтыг өөрчлөн найруулах.
15.	Төслийн 12.6.2. өөрийн хариуцах мэдээллийг өөрийн цахим хуудсанд олон нийтэд ойлгомжтой байдлаар байршуулан мэдээлэх, тогтмол шинэчлэх	Төслийн 12.6.2-т "... өөрийн хариуцах мэдээллийг өөрийн цахим хуудсанд..." гэж тусгасан нь ойлгомжгүй байна.	Тус зохицуулалтыг өөрчлөн найруулах.

16.	Төслийн 12.6.6. мэдээллийн санд оруулсан мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах;	Төслийн 12.6.6-д “...бүрэн байдлыг...” гэж тусгасан нь учир дутагдалтай байна.	Тус заалтыг “...бүрэн гүйцэд байдлыг...” гэж өөрчлөх.
17.	Төслийн 12.6.7. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх;	Төслийн 12.6.7-д олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль тогтоомж гэж тусгасан “...тухай...” гэх үгийг орхигдуулсан байна.	Төслийн 12.6.7-д “...ил тод байдлын...” гэсний дараа “...тухай...” гэж нэмж оруулах. Өөрөөр хэлбэл, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль тогтоомж гэх.
18.	Төслийн 13.4. Мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн санд хандах, нэвтрэх, энэ хуулийн 14.7.10-т заасан нэгдсэн порталд холбох журмыг Засгийн газар батална.	Төслийн 13.4-т “... энэ хуулийн 14.7.10-т заасан нэгдсэн порталд холбох...” гэж заажээ. Төслийн 14.7.10-т “...олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, тухайн газар, объектод саадгүй нэвтрэх, холбогдох мэдээ, баримт бичгийг гаргуулж танилцах, түүнийг хуулбарлан авах, шаардлагатай тохиолдолд холбогдох шинжээч, мэргэжилтэн оролцуулж дүгнэлт гаргуулах, мэдээлэл, ил тод байдлын тайлангийн үнэн зөв байдлыг нягтлах...” гэж заасан нь төслийн 13.4-т заасан нэгдсэн порталд холбохтой хамааралгүй зохицуулалт байна. Харин төслийн 14.7.11-д “...энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн сангийн үйл ажиллагааг холбосон олборлох үйлдвэрлэлийн нэгдсэн портал ажиллуулах...” гэсэн нь төслийн 13.4-т хамааралтай зохицуулалт байна.	Төслийн 13.4 дэх хэсгийг “... энэ хуулийн 14.7.11-д заасан нэгдсэн порталд холбох...” гэж өөрчлөх.
19.	Төслийн 13.8 дугаар зүйл.	Төслийн 13 дугаар зүйлд 13.8 дахь хэсэг давхардсан буюу 13.9 дэх заалтыг 13.8 гэж бичсэн байна.	Төслийн 13.8 дахь хэсгийн дараа бичигдсэн 13.8 гэснийг 13.9 гэж өөрчлөх.

20.	Төслийн зарим зүйл, заалт	Төслийн зарим зүйл заалтад өөр хуулиас иш татахдаа тухайлбал, төслийн 7.1.9.г-д “...Газрын тосны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Ашигт малтмалын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д...” гэж тусгасан хэр нь зарим тохиолдолд тухайлбал, төслийн 7.1.7.й-д “...Ашигт малтмалын тухай хуулийн 43.2-т...” гэж ялгамжтай байдлаар тусгажээ.	Иймд бусад хуулиар иш татахдаа тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д гэж нэгдсэн байдлаар бичих нь зүйтэй.
21.	Төслийн 14.7.2-т “...олборлох үйлдвэрлэлд үйл ажиллагаатай холбогдуулан...”	Төслийн 14.7.2-т “...олборлох үйлдвэрлэлд үйл ажиллагаатай холбогдуулан...” гэж тусгасан нь ойлгомжгүй байна. Учир нь үйлдвэрлэл гэх үгэнд өгөх оршихын тийн ялгалын “-д” нөхцөл бус харьяалахын тийн ялгалын “-ийн” нөхцөлийг залгаж бичсэнээр энэхүү өгүүлбэр утга зүйн алдаагүй байдлаар бичигдэнэ.	Төслийн 14.7.2 дахь заалтыг “...олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбогдуулан...” гэж өөрчлөх.
22.	Төслийн 14.7.3-т “...олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг үндэслэн...”	Төслийн 14.7.3-т “... ил тод байдлын тайланг үндэслэн...” гэж тусгасан нь найруулга зүйн алдаатай байна. Тус заалтын тайлан гэх үгэнд өгөх оршихын тийн ялгалын “-д” нөхцөлийг залгах нь зүйтэй.	Төслийн 14.7.3-т “...тайланд үндэслэн...” гэж өөрчлөх.
23.	Төслийн 14.7.7-д “...мэдээлэл бүрэн нийлүүлэгдэж байгаа эсэхэд хяналт тавих, хяналт тавих, энэ чиглэлээр...”	Төслийн 14.7.7-д “...хяналт тавих, хяналт тавих...” гэж давхардуулан бичсэн байна.	Төслийн 14.7.7-д заасан “...хяналт тавих, хяналт тавих...” гэсний нэгийг хасах.
24.	Төслийн 14.8. Үндэсний зөвлөл нь төр, зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллагын тэнцвэртэй төлөөллөөс бүрдсэн, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий салбар	Төслийн 14.8-д “...төлөөллөөс бүрдсэн, олборлох...” гэж таслалтай бичсэн нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Мөн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль тогтоомж гэж “...тухай...” гэх үгийг орхигдуулан бичсэн байна.	Хоёрдмол ойлголтыг залруулах үүднээс холбоо үгийн дундах таслалыг арилгах. Мөн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль тогтоомж гэх.

	зөвлөлийг байгуулж болно.		
25.	Төслийн 15.6.Зөвшөөрөл эзэмшигч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуульд заасан хугацаанд тухайн жилийн тайлан гаргах боломжгүй болсон тухай Үндэсний зөвлөлд мэдэгдсэн бол Үндэсний зөвлөл тайлан гаргах хугацааг 6 сараар хойшлуулж болно.	Төслийн 15 дугаар зүйлд Үндэсний зөвлөлийн ажлын албаны талаарх зохицуулалтыг тусгасан боловч төслийн 15.6 дахь хэсэгт заасан зохицуулалт нь Үндэсний зөвлөлийн ажлын албатай холбоотой зохицуулалт бус Үндэсний зөвлөл буюу төслийн 14 дүгээр зүйлтэй илүү уялдаа холбоотой зохицуулалт байна.	Тус зохицуулалтыг хуулийн төслийн 14 дүгээр зүйл рүү оруулах.
26.	Төслийн 19.1.Зөвшөөрөл эзэмшигчээс хандив, тусламж, дэмжлэг, урамшуулал зэрэг болон бусад аливаа хэлбэрээр санхүүжилт авсан иргэний нийгмийн байгууллага энэ хуулийн 16.1.3-т заасан ил тод байдлын тайланг жилээр гаргаж дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор холбогдох мэдээллийн санд цахимаар оруулна.	Төслийн 19.1-д “...ил тод байдлын тайланг жилээр гаргаж...” гэснийг төслийн бусад зохицуулалттай уялдуулан “...тухайн жилийн ил тод байдлын тайланг...” гэж өөрчлөх. “...урамшуулал зэрэг болон... бусад аливаа” гэсэн нь найруулгын алдаатай байдлыг бий болгож байна. Учир нь зэрэг болон гэх холбох үгсийг нэг дор зэрэгцүүлэн бичсэн, мөн бусад аливаа гэх үгсийн нэг дор бичсэн нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Мөн төслийн “...энэ хуулийн 16.1.3-т заасан...” гэснийг хасах. Үүнийг үнэлгээний тайлангийн харилцан уялдаа хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан болно.	Төслийн 19.1. Зөвшөөрөл эзэмшигчээс хандив, тусламж, дэмжлэг, урамшуулал болон бусад хэлбэрээр санхүүжилт авсан иргэний нийгмийн байгууллага нь тухайн жилийн ил тод байдлын тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор гаргаж, холбогдох мэдээллийн санд оруулна.
27.	Төслийн 21.4..Ажлын алба нь тайлангийн зөрүүг шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл энэ талаар тайлбар, зөвлөмжийг олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланд тусгах бөгөөд энэ талаар тайлан гаргах үүрэг бүхий этгээдэд мэдэгдэнэ.	Төслийн 21.4 дэх хэсэгт “...энэ талаар...” гэж хоёр удаа бичсэн байна.	Төслийн 21.4.”Ажлын алба нь тайлангийн зөрүүг шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл энэ талаар тайлбар, зөвлөмж гаргаж олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланд тусган, тайлан гаргах үүрэг бүхий этгээдэд мэдэгдэнэ” гэж өөрчлөх.

28.	Төслийн зарим заалтын тайлбар хэсэг.	Төсөлд хуулийн нэр томьёо тодорхойлолт гэх хэсэг байгаа боловч төслийн зарим зохицуулалт дор тайлбар хийсэн байна. Тус тайлбаруудаас хуулийн нэр томьёонд хамаарах хэсгийг төслийн 4 дүгээр зүйлд тусгах нь зүйтэй.	Төслийн зарим заалтын тайлбарыг хуулийн нэр томьёо хэсэгт тусгах.
29.	Төслийн 12.6.3, 12.9, 18.1 дэх хэсэг.	Төслийн 12.6.3, 12.9, 18.1 дэх хэсэгт заасан зохицуулалтад "...дотор багтаан..." гэж тусгасан нь найруулга зүйн алдаатай байдлыг бий болгож байна.	Төслийн 12.6.3, 12.9, 18.1 дэх хэсэгт заасан зохицуулалтын "...дотор багтаан..." гэснийг "...дотор..." гэж өөрчлөх.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд “эрдэс баялаг олборлох үйлдвэрлэл” гэх нэр томьёог 17 удаа, харин “эрдэс баялгийг олборлох үйлдвэрлэл” гэх нэр томьёог 3 удаа ашиглажээ. Ийнхүү ажил төстэй нэр томьёог ялгаатай байдлаар хэрэглэх нь нэр томьёоны хувьд төөрөгдөл бий болгоно. Иймд тус хуулийн төсөлд дурдсан “эрдэс баялгийг олборлох үйлдвэрлэл” гэх нэр томьёог “эрдэс баялаг олборлох үйлдвэрлэл” гэж **өөрчлөх саналтай байна.**

Хүснэгт 17. Эрдэс баялаг олборлох үйлдвэрлэл, эрдэс баялгийг олборлох үйлдвэрлэл гэж хоёр өөр байдлаар бичигдсэн төслийн зүйл заалт

№	Эрдэс баялаг олборлох үйлдвэрлэл	Эрдэс баялгийг олборлох үйлдвэрлэл
1	6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт	7 дугаар зүйлийн 7.1.8а дэд заалт
2	7 дугаар зүйл.	7 дугаар зүйлийн 7.1.13в дэд заалт
3	7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг	7 дугаар зүйлийн 7.1.14а дэд заалт
4	7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт	
5	7 дугаар зүйлийн 7.1.10ё дэд заалт	
6	7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт	
7	7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт	
8	7 дугаар зүйлийн 7.1.14 дэх заалт	
9	7 дугаар зүйлийн 7.1.14в дэх дэд заалт	
10	7 дугаар зүйлийн 7.1.15 дахь заалт	
11	13 дугаар зүйлийн 13.2 дахь заалт	
12	20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг	

13	20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт	
14	20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт	
15	20 дугаар зүйлийн 20.2.8 дахь заалт	
16	20 дугаар зүйлийн 20.2.10 дахь заалт	
17	20 дугаар зүйлийн 20.2.11 дэх заалт	

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Харилцан уялдаа” гэсэн шалгуурын хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуурын хүрээнд зохицуулалт бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгана. Өөрөөр хэлбэл, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн харилцан уялдаа холбоог шалгах шалгуур үзүүлэлтийн хүрээнд давхардал, хийдэл, зөрчлийг судлан, дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Хүснэгт 18. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал.

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл гэх нэр нь хуулийн төсөл хийгээд төслийн үзэл баримтлалын агуулгатай нийцэж байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Төслийн 14.6-д “ <i>геологи, уул уурхайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн Үндэсний зөвлөлийн даргыг Засгийн газарт санал болгоно</i> ” гэж хуульчилсан. 1993 оны Засгийн газрын тухай хуульд засгаар геологийн асуудлыг уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд эрхлэхээр заасан. Иймд тус хуулийн заалттай нийцүүлэн 14.6 дахь хэсгийн “ <i>геологи, уурхайн асуудал хариуцсан</i> ” гэснийг уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн гэж өөрчлөх нь зүйтэй.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Төслийн 15.2-т “ <i>Үндэсний зөвлөл нь Ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратегийг баталж, үйл ажиллагааны төсвийн саналыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Ерөнхий сайдад хүргүүлнэ</i> ” гэж заасан боловч төслийн 21 дүгээр зүйлд Ерөнхий сайдтай холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна.
	Төслийн 19.1-д “ <i>...Зөвшөөрөл эзэмшигчээс хандив, тусламж, дэмжлэг, урамшуулал зэрэг болон бусад аливаа хэлбэрээр санхүүжилт авсан иргэний нийгмийн байгууллага энэ хуулийн 16.1.3-т заасан ил тод байдлын тайланг жилээр гаргаж дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор холбогдох мэдээллийн санд цахимаар оруулна...</i> ” гэж заасан боловч тус төслийн 16.1.3-т “ <i>иргэний нийгмийн байгууллагын</i> ” гэх зохицуулалт байна. Өөрөөр хэлбэл, төслийн 16.1-д олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан салбар тус бүрд ямар төрөлтэй байхыг тусгасан бөгөөд тухайн төрлүүдийн нэг нь 16.1.3-т заасан иргэний нийгмийн байгууллагын тайлан юм. Иймд төслийн 19.1 дэх хэсэгт заасан зохицуулалтаас “ <i>...энэ хуулийн 16.1.3-т заасан...</i> ” гэснийг хасах нь зүйтэй.

Төслийн 17.2, 18.3, 19.1 дэх хэсэгт заасан зохицуулалтуудаас харвал тухайн жилийн мэдээллийн ил тод байдлын тайланг дараа оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн дотор гаргахаар ойлгогдож байгаа боловч мэдээллийн санд оруулахдаа:

- Мэдээллийн санд оруулна.
- Мэдээллийн санд цахимаар оруулна гэж ялгамжтай зохицуулсан байна.

Энэ нь иргэний нийгмийн байгууллага мэдээлэл нийлүүлэгчид хамаарахгүй учир мэдээллийн санд цахимаар мэдээллээ оруулахаар тусгайлан зохицуулсан мэт харагдаж байна.

Мөн төслийн 6.7-д заасан зохицуулалтаас харвал, мэдээллийн санд мэдээлэл оруулах хугацаа, маягт, журмыг Үндэсний зөвлөлөөс батлахаар тусгасан боловч төслийн 17.2, 19.1-д ил тод байдлын тайлан гаргаж мэдээллийн санд оруулахаар, харин төслийн 18.3-т Үндэсний зөвлөлөөс баталсан маягтын дагуу тайлан гаргаж, мэдээллийн санд оруулахаар зохицуулжээ.

Түүнчлэн, төслийн 18.3-т заасан Үндэсний зөвлөлөөс баталсан маягт гэдэг нь төслийн 6.7, 18.2 дахь хэсэгт заасан маягтын аль нь болох, эсхүл энэ хоёр зохицуулалт дахь маягт гэх ойлголт нь ижил утгатай эсэх нь тодорхойгүй байна.

Төслийн 16.2-т “...Энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан тайлангийн маягтыг энэ хуулийн 7, 8, 9, 10, 11 дүгээр зүйлд заасан мэдээлэл бүрийг хамруулж Үндэсний зөвлөл батална...” гэж заасан бөгөөд төслийн 16.1-д олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлангийн төрлийг тодорхойлсон бөгөөд төслийн:

16.1.1.төрийн байгууллагын;

16.1.2.зөвшөөрөл эзэмшигчийн гэж заажээ. Дээрх зохицуулалтаас дүгнэвэл, төрийн байгууллагын, зөвшөөрөл эзэмшигч аль аль нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлангаа Үндэсний зөвлөлөөс баталсан тайлангийн маягтыг дагуу гаргахаар ойлгогдож байна. Гэтэл төслийн 17.2-т “...Мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага нь тухайн жилийн ил тод байдлын тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор гаргаж, мэдээллийн санд оруулна...” гэж, төслийн 18.3-т “...Зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилийн ил тод байдлын тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Үндэсний зөвлөлөөс баталсан **маягтын дагуу** гаргаж, мэдээллийн санд оруулах үүрэгтэй...” гэж тус тус заажээ.

Өөрөөр хэлбэл, тус 2 зохицуулалтаас харвал, зөвшөөрөл эзэмшигч нь Үндэсний зөвлөлөөс баталсан маягтын дагуу, Төрийн байгууллага бол заавал маягт гэхгүйгээр шууд ил тод байдлын тайлангаа гаргаж болохоор ойлгогдож байна. Иймд төслийн 17.2 дахь хэсэгт заасан зохицуулалтыг төслийн 16.2, 18.3 дахь зохицуулалттай уялдуулан “...Мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага нь тухайн жилийн ил тод байдлын тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Үндэсний зөвлөлөөс баталсан маягтын дагуу гаргаж, мэдээллийн санд оруулна...” өөрчлөх.

ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Тус судалгаагаар Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн зорилт /хуулийн төслийн 1 дүгээр зүйл/, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын зарчим /хуулийн төслийн 5 дугаар зүйл/, Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн /хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2/, Үндэсний зөвлөл дэх зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн бүрэн эрхийн хугацаа /хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2/-д хамаарах эрх зүйн хэм хэмжээ нь зорилгод нийцэж буй эсэх, Мөн хуулийн төслийн Үндэсний зөвлөлийн чиг үүрэг /хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1/, иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлын тайлан /хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1/-д хамаарах эрх зүйн хэм хэмжээ нь практик хэрэгжих эсэх, түүнчлэн хуулийн төсөл бүхэлд нь ойлгомжтой болон, харилцан уялдаатай эсэхэд дүн шинжилгээ хийн дараах дүгнэлт, зөвлөмжийг дэвшүүлж байна.

1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн **зорилт** /хуулийн төслийн 1 дүгээр зүйл/, **олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын зарчим** /хуулийн төслийн 5 дугаар зүйл/, **Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн** /хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2/-д заасан хэм хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь заалтын үзэл баримтлал болон холбогдох бусад дээд эрэмбийн хэм хэмжээнд заасан зорилгод нийцэж байна. Гэхдээ дараах агуулгыг анхаарах шаардлагатай байна.

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 1.1-д заасан *“Байгалийн баялгийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх”* зорилт нь тус хуулийн зүйл заалттай хэрхэн уялдах буюу байгалийн баялгийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэхтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээ олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд байхгүй. Иймд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 1.1-д заасан *“Байгалийн баялгийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх”* зорилтыг хэрэгжүүлэх эрх хэм хэмжээг тус хуулийн төслөөс хасах;
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.4-д заасан Ил тод, нээлттэй, хариуцлагатай, ёс зүйтэй, эрх тэгш, шударга өрсөлдөөн дэмжих, бүрэн, үнэн зөв, тогтмол шинэчлэгддэг байх зарчмыг нэр томъёоны тодорхойлолт хэсэгт тайлбарлах, хуулийн төслийн аль бүлэгт, ямар хэм хэмжээгээр илэрч буй талаар хуулийн төслийн 5 дугаар зүйлд нарийвчлан тусгах шаардлагатай. Ингэхдээ Мөн Ирээдүй өв сангийн тухай хуулийн 6 дугаар зүйл заасантай төстэй байдлаар зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой хэм хэмжээ нэмэх. Ингэснээр Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд заасан зарчмыг нэг мөр ойлгох боломж бүрдэнэ.
- ОУИТБС-ын 12 зарчмын нэг болох мэдээллийн санг ашиглахад хялбар, ойлгомжтой байх зарчмыг олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд нэмэх;
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалтыг *“Үндэсний зөвлөл нь Хүний эрхийн үндэсний комисс, Авлигатай тэмцэх газар, байгаль орчин, геологи уул уурхай, санхүү төсөв, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага”* гэж таслалыг арилгаж өөрчлөх;

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2-д *“төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх бусад холбогдох төрийн байгууллага”* гэж ямар төрийн байгууллагыг хэлж байгаа, цаашлаад тус байгууллагаас Үндэсний зөвлөлд орон тоог тодорхой болгох;
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2-д *төр, хувийн хэвшил, иргэний байгууллагаас Үндэсний зөвлөлд сонгогдох гишүүдийн тооны харьцааг тэнцвэртэй, байдлаар тусгах;*
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.3-д *Үндэсний зөвлөл дэх зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг 3 жилийн хугацаанд томилох заасан байгааг өөрчлөх нь зүйтэй. Ингэхдээ Үндэсний зөвлөл дэх төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хугацаатай адил болгох, эсхүл бусад зөвлөлийн адилаар 6 жилийн хугацаагаар сонгох нь зүйтэй* байна.

2. Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн хуулийн төслийн **Үндэсний зөвлөлийн чиг үүрэг** /хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1/, **иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлын тайлан** /хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1/-д хамаарах эрх зүйн хэм хэмжээ сонгон үнэлсэн бөгөөд дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргалаа. Үүнд:

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан Үндэсний зөвлөлд хамаарах эрх зүйн хэм хэмжээ нь сүүлийн 18 гаруй жилийн хугацаанд практик хэрэгжиж иржээ. Гэхдээ жилд 1,2 удаа хуралддаг, төрийн байгууллагын төлөөлөл тэр бүр оролцдоггүй зэрэг хүндрэлүүд байгааг анхаарах шаардлагатай. Тодруулбал, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 2006 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирсэн боловч ОУИТБС-ын цахим сайтын мэдээлэл 2019 оноос хойш шинэчлэгдээгүй, мэдээлэл хэт ерөнхий зэрэг хүндрэл байгааг анхаарах нь зүйтэй.
- Төслийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг заасан зохицуулалтын практик хэрэгжилтийг судлахаас өмнө тус зохицуулалт нь найруулга зүйн хувьд алдаатай байгааг дурдах нь зүйтэй.
- Төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигчийн хувьд мэдээллийн санд мэдээлэл оруулахдаа мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулна. Харин иргэний нийгмийн байгууллагын хувьд мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулах зохицуулалт байхгүй. Өөрөөр хэлбэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй хэрэглэгч мэдээллийн санд мэдээлэл оруулах боломжгүй байна. Гэтэл төслийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт иргэний нийгмийн байгууллага ил тод байдлын тайлангаа мэдээллийн санд цахимаар оруулахаар тусгасан зохицуулалтыг практикт хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд үнэлсэн. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн найруулга болон хэл зүйн агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон байна. Мөн логик дэс дараалалтай боловсруулагдсан бөгөөд хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ийг баримталсан. Мөн олборлох

үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн ойлгомжтой байдлыг сайжруулахын дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Төслийн 3.1-д заасан зохицуулалтын дараалалтай уялдуулан төслийн 6.1.1-6.1.5-д заасан мэдээллийн сангийн төрлийн дарааллыг өөрчлөх;
- Төслийн 3.1.1-д эрдэс баялаг хайх, ашиглах үйл ажиллагааг гэснийг төслийн 6.1.1-д заасан эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа гэсэнтэй уялдуулан нэг мөр болгох;
- Төслийн 5.1.4-т “..мэдээлэл нь бүрэн гэсний дараа гүйцэд...” гэж нэмж оруулах;
- Төслийн 6.6-д “...үүрэг бүхий этгээд баталгаажуулах...” гэж заасныг ...Мэдээллийн санд мэдээлэл оруулах, өөрчлөх, шинэчлэх үүрэг бүхий этгээдийг баталгаажуулах ажлыг цахимаар гүйцэтгэнэ...” гэж өөрчлөх;
- Төслийн 4 дүгээр зүйлд заасан хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт “нээлттэй мэдээлэл” гэх ойлголтыг нэмэх;
- Төслийн 7.1.4 б дэх заалтыг 7.1.4а гэж өөрчлөх;
- Төслийн 7.1.4г. “Ашигт малтмалын тухай хуулийн 35.4-т заасан комиссын шийдвэр” гэж заасан. Харин “Ашигт малтмалын тухай хуулийн 35.4-т дахь заалтад комиссын шийдвэртэй холбоотой хэм хэмжээ байхгүй. Иймд Төслийн 7.1.4г.”Ашигт малтмалын тухай хуулийн 35.4-т заасан комиссын шийдвэр” гэж заасныг өөрчлөх;
- Төсөлд заалтад “эрдэс баялаг олборлох үйлдвэрлэл” болон “эрдэс баялгийн олборлох үйлдвэр” гэж ижил агуулга нэг нэр томъёог ялгамжтай байдлаар төсөлд заасныг нэр мөр болгох;
- Төслийн 10 дугаар зүйл, 10.1 дэх хэсэг, 10.1.1 дэх заалтын “...амьтан барих, агнах...” гэснийг “...амьтан агнах, барих...” гэж өөрчлөх;
- Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 11.1.6 дахь заалтыг нэгтгэх;
- Төслийн 12 дугаар зүйлийн 12.4-т “...холбогдох мэдээллийн сан хариуцагчаас мэдэгдсэнээр заасан хугацаанд мэдээлэл нийлүүлэгч нь мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулах үүрэг хүлээнэ...” гэж тусгасан нь найруулга зүй, утга агуулгын хувьд ойлгомжгүй тул өөрчлөн найруулах;
- Төслийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.7 дахь заалтын зохицуулалтыг төслийн мөн зүйлийн 12.6 дахь хэсэгт оруулах;
- Төслийн 12 дугаар зүйлийн 12.6.1-д “...олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг ил тод байлгах...” гэж заасан нь найруулга зүй алдаатай байх тул өөрчлөн найруулах;
- Төслийн 12 дугаар зүйлийн 12.6.2-т “...өөрийн хариуцах мэдээллийг өөрийн цахим хуудсанд...” гэж тусгасан нь ойлгомжгүй тул өөрчлөх найруулах;
- Төслийн 12 дугаар зүйлийн 12.6.6-д “...бүрэн байдлыг...” гэж тусгасан нь учир дутагдалтай тул тус заалтыг “...бүрэн гүйцэд байдлыг...” гэж өөрчлөх;

- Төслийн 12 дугаар 12.6.7-д “...ил тод байдлын...” гэсний дараа “...тухай...” гэж оруулах;
- Төслийн 13 дугаар зүйлийн 13.8 дахь заалт давхардсан тул өөрчлөх;
- Төслийн зарим зүйл заалтад өөр хуулиас иш татахдаа ялгамжтай байдлаар бичсэнийг нэгтгэж, хууль тогтоомжийн тухай хууль заасны дагуу өөрчлөх;
- Төслийн 14 дүгээр 14.7.2 дахь заалтыг “...олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбогдуулан...” гэж өөрчлөх;
- Төслийн 14 дүгээр зүйлийн 14.7.7-д “...хяналт тавих, хяналт тавих..” гэж давхардуулан бичсэн тул нэгийг хасаж, өөрчлөх;
- Төслийн 14 дүгээр 14.8-д “...төлөөллөөс бүрдсэн, олборлох...” гэж таслалтай бичсэн нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Иймд хоёрдмол ойлголтыг залруулах үүднээс холбоо үгийн дундах таслалыг арилгах;
- Төслийн 14 дүгээр 14.8-д Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль тогтоомж гэж “...тухай...” гэх үгийг орхигдуулан бичсэн тул олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль тогтоомж гэж өөрчлөх;
- Төслийн 21 дүгээр зүйлийн 21.4.”Ажлын алба нь тайлангийн зөрүүг шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл энэ талаар тайлбар, зөвлөмж гаргаж олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланд тусган, тайлан гаргах үүрэг бүхий этгээдэд мэдэгдэнэ” гэж өөрчлөх;

Төсөлд хуулийн нэр томъёоны тодорхойлолт гэх хэсэг байгаа боловч төслийн зарим зохицуулалт дор тайлбар хийсэн байна. Тус тайлбаруудаас хуулийн нэр томъёонд хамаарах хэсгийг төслийн 4 дүгээр зүйлд тусгах нь зүйтэй.

4.Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд үнэлсэн бөгөөд дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Төслийн 14 дүгээр зүйлийн 14.6-д “*геологи, уул уурхайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн Үндэсний зөвлөлийн даргыг Засгийн газарт санал болгоно*” гэж хуульчилсан. 1993 оны Засгийн газрын тухай хуульд засгаар геологийн асуудлыг уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд эрхлэхээр заасан. Иймд тус хуулийн заалтай нийцүүлэн 14.6 дахь заалтын “*геологи, уурхайн асуудал хариуцсан*” гэснийг “*уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн*” гэж өөрчлөх нь зүйтэй.
- Төслийн 15 дугаар зүйлийн 15.2-т “*Үндэсний зөвлөл нь Ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратегийг баталж, үйл ажиллагааны төсвийн саналыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Ерөнхий сайдад хүргүүлнэ*” гэж заасан боловч төслийн 21 дүгээр зүйлд Ерөнхий сайдтай холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна.
- Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “*...Зөвшөөрөл эзэмшигчээс хандив, тусламж, дэмжлэг, урамшуулал зэрэг болон бусад аливаа хэлбэрээр санхүүжилт авсан иргэний нийгмийн байгууллага энэ хуулийн 16.1.3-т заасан ил тод байдлын тайланг жилээр гаргаж дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор холбогдох мэдээллийн санд цахимаар оруулна...*” гэж заасан боловч тус

төслийн 16.1.3-т “иргэний нийгмийн байгууллагын” гэх зохицуулалт байна. Өөрөөр хэлбэл, төслийн 16.1-д олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан салбар тус бүрд ямар төрөлтэй байхыг тусгасан бөгөөд тухайн төрлүүдийн нэг нь 16.1.3-т заасан иргэний нийгмийн байгууллагын тайлан юм. Иймд төслийн 19.1 дэх хэсэгт заасан зохицуулалтаас “...энэ хуулийн 16.1.3-т заасан...” гэснийг хасах нь зүйтэй.

- Төслийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан Үндэсний зөвлөлөөс баталсан маягт гэдэг нь төслийн 6.7, 18.2 дахь хэсэгт заасан маягтын аль нь болох, эсхүл энэ хоёр зохицуулалт дахь маягт гэх ойлголт нь ижил утгатай эсэх нь тодорхойгүй байна.
- Төслийн 17.2 дахь хэсэгт заасан зохицуулалтыг төслийн 16.2, 18.3 дахь зохицуулалттай уялдуулан өөрчлөх нь зүйтэй байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992), <https://legalinfo.mn/mn/detail/367>
2. Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль, УБ, (1993), <https://legalinfo.mn/mn/detail/344>
3. Ирээдүй өв сангийн тухай хууль, УБ, (2016), <https://legalinfo.mn/mn/detail/11707>
4. Монгол Улсын Их Хурлын тогтоол, УБ, (2020), Дугаар 02, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14950>
5. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=210458&showType=1>.
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, УБ, (2023)

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. Д.Баярсайхан, Эрх зүйн онол, УБ, 2017
2. НҮБ-ийн Хүний эрх ба Хүрээлэн буй орчны асуудал хариуцсан Тусгай илтгэгч Жон Ноксийн тайлан, 2017.
3. О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, УБ, 2021.
4. Монгол Улсын Их Сургууль, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Үндсэн хууль манай сургуульд УБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар, сургалтын хөтөлбөр, УБ, 2022.
5. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, УБ, 2023.

Гадаад хэлээр:

1. The Extractive Industries Transparency Initiative (EITI) principles, <https://eiti.org/documents/eiti-principles>,
2. The Extractive Industries Transparency Initiative standard, 2023, <https://eiti.org/sites/default/files/2023-06/2023%20EITI%20Standard.pdf>,

Цахим эх сурвалж

7. Нээлттэй нийгэм форум, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга:Олон Улсын зөвлөх бүлгийн тайлан, УБ, 2006, https://forum.mn/uploads/site/1126/res_mat/OlborlohUildverlelSanaachilga.pdf,
8. Нээлттэй нийгэм форум, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хэрэгцээ, шаардлага, урьдчилсан тандан, Судалгааны тайлан, УБ, 2020, <https://forum.mn/product/152515>,

9. Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга,
<https://www.eitimongolia.mn/p/3>,